

“ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ ХАНГАХ АЯН”-Ы ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН

2017.09.25



ҮАГ-аас зарласан “Зөвлөмжийн биелэлтийг шалгах” аяны хүрээнд өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг завсрын аудитын хугацаанд үйлчлүүлэгч байгууллага бүр дээр очиж, хэрэгжилтийг шалгах хуудсаар шалгаж, үр дүнгийн талаар тайлан бичихээр удирдамж, хөтөлбөр батлан, зөвлөмж хэрэгжүүлж ажиллаагүй улсын болон орон нутгийн төсөвт байгууллагын төсөв захирагч, нягтлан бодогч нарт хариуцлага тооцуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Дээрх ажлын хүрээнд байгууллагын албадууд санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитаар өгөгдсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг шалгах аар байгууллагуудад хуваарийн дагуу ажиллаж байна. “Завсрын аудит”-ын хөтөлбөр, “Зөвлөмжийн хэрэгжилт шалгах удирдамж”-ийн дагуу 2017 онд өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт, өмнөх оноос шилжиж ирсэн хэрэгжээгүй зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актуудыг шалгаж үр дүнг тооцохоор төлөвлөн, 9 дүгээр сарын 25-ны байдлаар 6 байгууллагад ажиллаад байна.

Санхүүгийн тайлангийн аудитын тайлагналын дараах үе шатны ажлын хэрэгжилт

Зөвлөмжийн хэрэгжилт

Төсөв захирагчдын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 156 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийг агуулгаар харуулбал 8 буюу 5.1 хувь нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөг сайжруулах, 63 буюу 40.4 хувь нь бүртгэл тайлагналтай холбоотой, 29 буюу 18.6 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 42 буюу 26.9 хувь нь дотоод хяналтыг сайжруулах, 14 буюу 9 хувь нь бусад төрлийн зөвлөмжүүд өгөгджээ.

ҮАГ-аас зөвлөмж хэрэгжүүлэх сарын аяны хүрээнд зөвлөмжийн хэрэгжилтийг газар дээр нь үзэж үр дүнг тооцох ажил зохион байгуулж, аймгийн төвийн нийт 8 байгууллагад өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгалаа. Тухайлбал: Прокурор, Татварын хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба, Уламжлалт анагаах ухааны төв, Шийдвэр гүйцэтгэх алба, Онцгой байдлын газар, Математикийн гүнзгийрүүлсэн сургалттай 4 дүгээр сургууль, Номын сан зэрэг байгууллагууд хамрагдлаа.

2017 оны 3-р улирлын байдлаар 55 заалт бүхий зөвлөмж хэрэгжиж, нийт зөвлөмжийн хэрэгжилт 35.2 хувьтай болсон байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах явцад Дундговь телевиз татан буугдсанаас тухайн байгууллагад өгсөн 1 зөвлөмж хэрэгжих боломжгүй болсон байна.

Төлбөрийн актын хэрэгжилт

Төсөв захирагчдын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 26 заалт бүхий 9.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 7.0 сая төгрөгийн 20 төлбөрийн акт хэрэгжсэн. 1.9 сая төгрөгийн төлбөрийн акттай холбоотой өргөдөл ирүүлж, тухайн зөрчлийг дахин нягталж, эрхзүйн үндэслэлийг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тухайн актыг хүчингүй болгож 0.8 сая төгрөгийн 5 төлбөрийн актын үлдэгдэлтэй байна.

Албан шаардлагын хэрэгжилт

Төсөв захирагчдын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 76 заалт бүхий 2,580.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн. Үүнээс 57 заалт бүхий 2,294.5 сая төгрөгийн албан шаардлага хэрэгжиж, гүйцэтгэл 88.9 хувьтай байна.

Гүйцэтгэлийн аудитын мөрөөр хийсэн үйл ажиллагааны хэрэгжилт

Зөвлөмжийн хэрэгжилт

2017 оны 9 дүгээр сарын байдлаар нийт хэрэгжээгүй зөвлөмжийн үлдэгдэл 19 байна. Үүний 15 зөвлөмж нь өмнөх оноос шилжин ирсэн, 4 зөвлөмж нь тайлант оны хэрэгжээгүй үлдэгдэл байна. Нийт хэрэгжээгүй зөвлөмжийн 8 нь аймгийн Засаг дарга, 8 зөвлөмж нь Ерөнхий боловсролын сургуулиуд, Боловсрол соёл урлагийн газартай холбоотой, үлдсэн 3 зөвлөмж нь аймаг, сумдын Засаг даргын Тамгын газартай холбоотой зөвлөмжүүд байна.

Аймгийн Засаг даргатай холбоотой зөвлөмжийн хэрэгжилтийг холбогдох агентлаг, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, зөвлөмжийг хэрэгжүүлж, тайлан мэдээг албан ёсоор ирүүлэхийг мэдэгдсэн.

Ерөнхий боловсролын сургуулиудтай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аймгийн БСУГ-тай уулзалт зохион байгуулж аймаг, сумдын сургуулиудад үүрэг өгч, зөвлөмжийг хэрэгжүүлэн, тайланг нэгдсэн байдлаар ирүүлэх талаар зөвшилцлөө.

Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Тайлант онд гүйцэтгэлийн аудитаар 230.3 сая төгрөгийн, санхүүгийн тайлангийн аудитаар 15.0 сая төгрөгийн нийт 715.9 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж бүрэн хэрэгжсэн.

Өмнөх оноос шилжин ирсэн 470.5 сая төгрөгийн нэг албан шаардлага хэрэгжээгүй байна.

Өмнөх оноос 0.8 сая төгрөгийн төлбөрийн актын үлдэгдэл шилжин ирсэн. Актыг хариуцагч байгууллагуудтай төлбөрийг барагдуулах талаар уулзалт зохион байгуулж 0.3 сая төгрөгийн актыг барагдуулсан. Тайлант онд 0.098 сая төгрөгийн төлбөрийн акт тавьсан, хэрэгжилт ирүүлэх хугацаа болоогүй байна.

Нийцлийн аудитын мөрөөр хийсэн үйл ажиллагааны хэрэгжилт

Зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд 25 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 28 хувь нь арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах, 8 хувь нь бүртгэл тайлагналтай холбоотой, 24 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 36 хувь нь дотоод хяналтыг сайжуулах, 4 хувь нь бусад чиглэлээр өгсөн зөвлөмжүүд эзэлж байна.

Өмнөх оны зөвлөмжийн биелэлтийг 2017 онд хийгдсэн ОНХС-ийн аудитаар газар дээр нь очиж, хяналт хийсэн бөгөөд тайлант онд хийгдсэн аудитын албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг сумдад очиж ажиллах цаг хугацааны боломж гараагүй тул шалгаж амжаагүй байна.

Зөвлөмжийн биелэлтийг хангах сарын аяны хүрээнд өмнөх аудитаар аймгийн төвд өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг шалган ажиллаж байна.

Төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

2017 оны 9 сарын байдлаар өмнөх оны үлдэгдлээс төлбөрийн акт бүрэн барагдаж, 32.6 сая төгрөгийн 4 албан шаардлага бүрэн барагдсан.

Тайлант онд нийт 1,119.8 сая төгрөгийн 25 албан шаардлага, 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосноос 977.9 сая төгрөгийн 24 албан шаардлага, төлбөрийн акт бүрэн хэрэгжиж, 66.7 сая төгрөгийн 1 албан шаардлагын хэрэгжилт ирээгүй байна.

Цаашдаа өөрийн төлөвлөгөөт болон нэгдсэн төлөвлөгөөт аудитаар аймаг, сумдад ажиллахдаа акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалган баталгаажуулж ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Зөвлөмжийн биелэлтийг хангах аяны хүрээнд дээрх ажлуудыг зохион байгуулж, жилийн эцэс гэхэд өмнөх оны үлдэгдлийг барагдуулах, хэрэгжилтийг газар дээр нь шалгаснаар статистик мэдээг үлдэгдэлгүй гаргахаар зорьж байна.

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР